



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/164

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Бор-Өндөр, Хэрлэн суманд коронавируст халдвар /ковид-19/-ын сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан Хэрлэн сумруу орох, гарах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих үүрэг бүхий 10 постыг энэ оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 04 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэл 7 хоногийн хугацаанд томилж, үүрэг гүйцэтгэх 20 алба хаагчийн хоол, автомашины шатах тослох материалын зардал болон "Тусгаарлах байр -ны гадна талын хамгаалалтад үүрэг гүйцэтгэх 2 алба хаагчийн 14 хоногийн хоолны зардлыг хавсралтаар тус тус баталсугай.

2. Халдвар хамгааллын дэглэм тогтоох, сэжигтэй тохиолдолын хавьтлыг илрүүлэх, тархах эрсдэлтэй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж ажиллахад шаардагдах 5.149.500 /таван сая нэг зуун дөчин есөн мянга таван зуун/ төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

03 Аймгийн Засаг даргын 2021 оны
..... дугаар сарын өдрийн/...../2021
дугаар захирамжийн хавсралт



Хөрөнгө зарцуулалтын тооцоо

Байгууллагын нэр	ЗАРДЛЫН НЭР ТӨРӨЛ			ДҮН
	Шатахууны зардал	Хоолны зардал	Бичиг хэргийн зардал	
Цагдаагийн газар	1.689.500		100.000	1.789.500
Онцгой байдлын газар		3.360.000		3.360.000
ДҮН	1.689.500	3.360.000	100.000	5.149.500